

Монголын орчин үеийн түүхийн нэн чухал зангилаа асуудал-үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн (ҮЭЧХ)-ий анхдугаар үеийн үечлэл, шинж чанарын талаар хийсэн судалгаагаа үндэслэн толилуулан буй өгүүллийн зохиогч анх 1976 онд Олон улсын монголч эрдэмтдийн III их хуралд эрдэм шинжилгээний илтгэл тавьснаас хойш мөнхүү сэдэвт холбогдох судалгааны зарим өгүүлэл¹, ганц сэдэвт зохиол² туурвиснаас гадна Монгол тусгаар тогтнолоо сэргээсний 80 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хуралд илтгэл тавьж хэлэлцүүлэв³. Энэ бүхэн цөм анхдугаар үед холбогдох юм. Тэгвэл ҮЭЧХ-ий хоёр дахь үе гэж хөрш хоёр орон, монгол угсаатан тусгаар тогтносон үндэсний улсынхаа хүрээнд нэгдэх гэсэн шударга тэмцлийг улс төрийн аргаар хав сайдан хазаарлаж, хувааж ноёрхсон 1915 оны 6-р сарын гурван этгээдийн хэлэлцээр гэгчээс 1921 оны ардын хувьсгал хүртэлх хугацааг хамарч байгаа юм. Гурван этгээдийн хэлэлцээр гэгчээр үндэсний эрх чөлөөний хувьсгалт тэмцлийн анхдугаар үе-олноо өргөгдсөн Монгол улсын тусгаар тогтнолыг цуцалж, уг тэмцлийн төв болж байсан Ар Монголд ДИУ-ын харьяанд байх автономит эрх олгож бусад монголчуудыг Хятадын шууд захиргаанд байлгах болов. Халхын дөрвөн аймаг, Ховдын хязгаарыг Автономит Гадаад Монгол хэмээн нэрийдэж, түүнийг ДИУ-ын нутгийн нэг хэсэг гээд улс төр, нутаг дэвсгэрийн асуудлаар гадаад улстай гэрээ байгуулах эрхгүй зөвхөн худалдаа, үйлдвэрийн зэрэг зүйлээр гадаад улстай гэрээ хэлэлцээр байгуулах онц эрхтэй гэж зааснаас гадна Автономит Гадаад Монголын Засгийн газар дотоод бүх хэргээ өөрөө мэдэж шийдвэрлэнэ, Гадаад Монголын Богд Жибзундамба хутагт хааны цолыг ДИУ-ын ерөнхийлөгчөөс өргөмбилнэ, албан бичигт Дундад улсын оны цолыг Монголын 12 жилт цаг улирлын тоотой хавсран хэрэглэнэ гэж заагаад анх Монгол улсын цолоор зарлагдаж дараа нь оны цол болон хэрэглэгдэж байсан «Олноо өргөгдсөний» гэдэг яруу сонсголт цол-тодотголыг хүчингүй болгох зэргээр Монголын төрийн тусгаар тогтнол, бүрэн эрхийг хязгаарлаж урьд Хаант Орос улсаас Монголд тулган хүлээлгэж байгуулсан эрх тэгш биш хэ лэлцээрүүд, Орос ДИУ хоёроос Монголын тухай илтгэн гаргасан бичиг зэргийг бататгасан нь монголчуудын дургүйцлийг ихэд төрүүлэв. Нэн ялангуяа Монгол улсад дагаар ирж, нутаг орноо бүрэн чөлөөлж нэгдэхийн төлөө амь биеэ үл хайрлан тулалдаж байгаад гурван этгээдийн бага хурлаас гарах шийдвэрийг хүлээж, гал зогсоогоод өөрсдийн ашиг сонирхолд нийцсэн шийдвэр гаргахыг горьдон хүлээж байсан цэрэг эрсийг хамгаас их бухимдууллаа. Тэднийг тайтгаруулж, сэтгэлийг нь засахын тул автономит Гадаад Монголын Засгийн газар: «Одоо нэгэнт Дундад, Орос, Монгол гурван этгээдээр гэрээ бичиг хэлэлцэн тогтоосон ба дагаар орсон олон монголчуудын ялыг бүрэн төгсөөр хэлтрүүлсэн, бас дотоод Монголын хил хязгаарын зурвас газраа нүүдлийн иргэдийг (хятадуудыг-Л.Ж.) оруулахгүй гэх зэргээр харилцан бичиг солилцсон»⁴ гэж мэдэгдсэн нь бухимдлыг багасгасангүй, харин үндэс-

*Дорно дахин олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, түүхийн ухааны дэд эрдэмтэн.

нийхээ эрх чөлөөний төлөө Хятадын эсрэг урьд хийж байсан тэмцлээ дахин сэргээхэд хүргэв. Монголчуудын ҮЭЧХ дахин өрнөснөөр түүний хоёр дахь үе эхэлсэн гэж үзэж байна. Энэ үе нь дотроо харилцан уялдаатай ч өөрийн онцлог бүхий хэдэн шаттай байсан гэж үзэж болмоор байна. Үүнд:

1. ҮЭЧХ-ий анхдугаар эед 1913 оны эхнээс Өвөр Монголыг чөлөөлөхийн төлөө тулалдаж байгаад гурван этгээдийн хэлэлцээр байгуулагдахыг хүлээж байсан цэргийн бослогоор ҮЭЧХ-ий хоёр дахь шат эхэлж байгаа нь нэг талаар түрүүчийн тэмцлийн үргэлжлэл, нөгөө талаар уг тэмцэл нь шинээр бий болсон улс төрийн байдлыг сөрж гурван этгээдийн хэлэлцээрийг эсэргүүцсэн учраас урьдынх шиг дан ДИУ-ын эсрэг биш хэрэг дээрээ Хаант Орос, Гадаад Монголыг бас эсэргүүцсэн юм. Иймээс тэмцлийн төв нь Ар Монголд биш, харин Өвөр Монголд байсан. Түүний уулга нь Бавуужавын удирдлагаар гарсан зэвсэгт бослого юм. Бавуужав бол Зостын чуулганы зүүн Түмэдийн хошуунд* 1875 онд төрсөн хуяг эр бөгөөд 1912 оны намар нутгаасаа цэрэг элсүүлэн Монгол улсад дагаар ирж цэргийн хороон дарга болж, улмаар Өвөр Монголыг сэргийлэн хамгаалах таван замын цэрэг гаргахад цэргийн дэд түшмэлээр томилогдон Даригангын чиглэлээр явж гарамгай сайн байлдсан учраас шударга баатар цол, гүнгийн зэргээр шагнагдаж, дараа нь зүүн өмнө хязгаарын монголчуудыг төвшитгэн тохинуулах түшмэл болоод манлайбаатар Дамдинсүрэн 1914 оны эхээр Нийслэл Хүрээ рүү буцахад бүх цэргийг ерөнхийлөн захирах сайд болон дэвшсэн бөгөөд Олноо өргөгдсөн Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр гурван улсын хэлэлцээний дүнг хүлээж харьяат цэргээ гэдрэг татаж Өвөр Монголын үзэмчин, хуучид болон Халх өвөрлөгчийн зааг нутагт сэргийлэн суух болсон юм. Тэгэхдээ ДИУ-ын эсрэг зэвсэгт тэмцлээ сэргээн үргэлжлүүлэх бэлтгэлээ базааж Японтой харилцаж байсан. Тэр монголчууд бүгдээрээ нэгдэж их улс олон тогтнох хүсэлтэй байгааг олноо өргөгдсөн Монгол улсад дахин давтан илэрхийлж байлаа. Тухайлбал, 1915 оны 3 дугаар сарын 14-нд Монгол улсын Улсын хуралд өргөсөн бичигтээ өөрөө хэрхэн ажиллаж байгаагаа танилцуулахдаа: «...зарлигаар манай зэрэг хязгаарын цэргийг нам гүм сэргийлэн сууж цагийг хүлээтүгэй! Дэмий дураар урагш давшиж болохгүй хэмээн тушаасныг дагаж...миний бие нэгэнт зүүн өмнө хязгаарын сайдын тушаалд бүхий тулд...оролдсон албыг эрхэлж хорооны дарга, ангийн дарга, түшмэл бүхэнлүгээ зөвлөж монголчуудаа тохинуулах аргыг сүвэгчлэн Жирэм, Зост, Зуу-уд зэрэг гурван чуулган хошуудад тус тус түшмэл томилон албан бичиг авахуулан явуулаад цөм хаашаа хандах, хэнийг дагах учраа таслан ирүүлтүгэй хэмээн явуулсанд» тэдгээр чуулган хошууд цөм «амьдардаг хөрөнгө, амь биеийг цөм тэвчиж цэрэг болж Богд хааны өмнө морь нохой мэт цэргийн зүтгэл өргөө!» гэснийг дурдаад «эдүгээ манай энэ нэгэн замын бэлэн бүхий цэрэг ба олон хошуудын бэлтгэхээр томилсон цэрэг нэгэн түм гаруй хүнийг сайд миний бие тэргүүлэн олон хорооны дарга, түшмэд, ангийн дарга түшмэд нар цөм нэр хамтлан нэгэн сэтгэлээр улс төрийн өмнө зүтгэхийг батлан...улсын хоёр хурлын сайдууд танаа явуулаад гуйх нь:» гээд Орос улсаас хурдан буу нэг түм, буу бүрийг гурван мянган сумтай худалдан авч өгөхийг хүсээд: «...Ир гэн улсын бачлах гэрээг таслаад... үхэн байлдсугай! хэмээж бүхий учраа урьдаас гарган мэдүүлээд...чармайн зүтгэх манай олны үнэн сүсгийг хөсөрдүүлэхгүй гуйсан ёсоор Олноо өргөгдсөний тавдугаар (1915) оны зуны тэргүүн сарын шинийн нэгнээс (5-р сарын 14) урьд зарлан тушаахыг хүснэ. Хэрэв болзсон мөнхүү өдөр болтол сурган тушаахгүй

*Үүнийг бас Монголжин хошуу ч гэдэг. Одоогийн БНХАУ-ын Ляонин мужийн Фүишнь монгол үндэстний өөртөө засах Сянь (хошуу) мөн.

аваас...Хятад хулгай Юань Шикай лугаа эрэгчин эмэгчинг үзэлцэх явдлыг урьдаас гарган мэдүүлэх...»⁵ учраа мэдэгджээ. Уг өргөх бичгийн ард хороон дарга 10, жагсаалын дарга 20, ангийн дарга 28, ангийн хавсрагч дарга 18, бүгд 76 хүний нэрийг жагсааж тус бүрийн дор нь хурууны хэв дарсан байлаа. Энэ асуудлыг Монгол улсын дээд доод хурал тэр даруйд нь яаралтай хэлэлцээд: «Харьяат сайд эхлэн олноор ийнхүү төлөвлөсөн нь үнэхээр шударга санаа, зорилт мөн ажээ. Гагцхүү энэ хэр Орос улс харьяат (манай-Л.Ж.) улсад байлдаан бүхий цагт буу зэвсэг өгөхгүй хэмээсэн зүйл буй ба бас ч гэрээний хэрэгт их л харшлах тул гэрээг хэрхэн тогтоохыг хүлээвээс зохих мэт»⁶ хэмээн түүний бэлтгэж буй зэвсэгт бослогыг эрс хориглоогүй, харин гурван этгээдийн хэлэлцээний дүнг хүлээхийг анхааруулжээ. Гэтэл Бавуужав, үүний дараахан Улсын хуралд дахин бичиг өргөж «хятадууд, өвөр монголчуудыг тухайлбал, Бавуужавыг устгахаар бэлтгэж байна»⁷ гээд агт зэвсэг залгуулж өгөхийг гуйсан. Тэгэхэд Улсын хурал уг асуудлыг хэлэлцээд Бавуужавт зөвхөн агт морьд хүрэлцэхүйц тоогоор нэмж олгохыг зүүн хязгаарын Монголчуудыг дагуулан тохинуулах сайд Егүзэр хутагт Галсандашид тушаасан ажээ.

Бавуужав гурван этгээдийн хэлэлцээнээс Монголд ашигтай шийдвэр гарахгүй гэдгийг мэдэж байсан учраас Хятадын түрэмгийллийн эсрэг тулалдахаар бэлтгэж байтал 1915 оны 6-р сарын 7-ноос гурван этгээдийн хэлэлцээр гэгч хүчин төгөлдөр болжээ. Тэгэхэд Бавуужав гурван улсын хэлэлцээрийг, «түмэн үед хүртэл гутамшиг, элэглэлийг хоцроож, ялангуяа...Язгуур үндэсний нэгийг салгая гэсэн нь илэрхий болсны тулд үхэх мөхөхийг хүлээхээс эртхэнээ Хятад улсын зүг эрэгчин эмэгчинг тасалсугай» хэмээн зөвшөөрөн хүлээхгүй гэдгээ шууд мэдэгдэж Өвөр Монгол дахь хятад цэрэгтэй шууд тулалдаж, амжилттай давшиж эхэлсэн байна.

ДИУ Орос улс хоёр Бавуужавын бослогыг Автономит Гадаад Монголоор даруулах явуулга хийж, элдвээр шахамдуулсан тул Монголын Засгийн газар жанжин манлайбаатар Дамдинсүрэнг 1915 оны 7-р сард зүүн өмнөд хязгаарын түшмэл цэргийг ятган тохинуулах сайдаар томилон явуулав⁸. Гэтэл босогчид ятган тохинуулалтыг хүлээж авахгүй тэмцлээ үргэлжлүүлсээр байлаа. Тэгэхэд ДИУ Бавуужавын бослогыг дарах нэрийдлээр 1915 оны 11-р сард үлэмжхэн цэргийг Долоннуураас хөдөлгөж Шилийн голоор дайран Халхын Сэцэн хан аймгийн нутагт оруулж Егүзэрийн* хийдийг түйвээж Бавуужавын босогчдыг цохиж зайлуулан зүүн хязгаарын сайд Егүзэр хутагт Галсандашийг баривчлан авч явсны улмаас Автономит Гадаад Монгол, ДИУ-ын харилцаа нэлээд хурцдаад сүүлдээ Бавуужавын босогчдыг тал талаас нь цохих замд орсноор Монгол эх орныхоо тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүхэл бүтэн байдлын төлөө мөр зэрэгцэн тулалдаж явсан дайчин эрс бие биедээ дайсан болж байлдсан эмгэнэлт явдал гарсан билээ.

Япон улсын монголчуудын ҮЭЧХ-ий анхдугаар үед хожимдосоноо нөхөж, түүний дахин өрнөлтийн энэ үед дэмжигчээр гарч иржээ. ҮЭЧХ-ий удирдагч Бавуужав нь Гадаад Монгол, Орос улсын зүгээс дэмжлэг авч чадахгүй болсон учраас тэр үед Хятад оронд ДИУ-ыг эсэргүүцэж Манжийн хаант төрийг сэргээх зорилготой хөдөлгөөн өрнөж байсантай нэг дэж, Японоос тусламж авах замд орсон аж. Бавуужав 1916 оны зун Автономит Гадаад Монголын Засгийн газарт ирүүлсэн нэгэн бичигтээ: «Би Дундад улсын олгох эрх ашиг ба Гадаад Монголын ятган хөөх аясаар дагалдан зуурмаглаж хэрхэвч чадахгүй...Одоо гагцхүү чин журмыг барьж Манжийн төрийг мандуулахаар Манж ба Жибэн (Япон Л. Ж.) -ээс эш батыг олж нэгэнт зарласан бөгөөд Богд хааны туг тамгыг халсан боловч бүгдээр шүтээн болгон тахиж тавиглан буй»⁹ гэсэн

*Одоогийн Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын төв.

байдаг. Өвөр Монголын энд тэнд олон нийтийн хөдөлгөөн гарч Бавуужавтай холбоо тогтоон Хойд Хятадын цэргийн эрхтнийг эсэргүүцэн тэмцэж байлаа. Шударга баатар, Бавуужав 1916 оны 10-р сард Халуун голын тусгай орны захирагч сайдын цэрэгтэй Линьси* хэмээх хотын төлөө шургуу тулалдаж байгаад нас баржээ. Монголын тусгаар тогтнолын төлөө цөхрөлтгүй тэмцэгч энэ хүний хэдэн жилийн шаргуу тэмцэл ийнхүү эцэслэснээс хойш, харьяат цэргүүд нь нэгдмэл зохион байгуулалтгүй болж сарниад Өвөр Монголын нутгаар тарж, тал талын эсрэг хүчинд цохигдсон билээ. Хэдий тийм боловч монголчууд Хятадын цэргийн эрхтний дарангуйлалтай эвлэршгүй тэмцсээр газар бүр л түүнийг ямар нэг хэмжээгээр эсэргүүцэж байв.

Өвөр Монголд Хятадын колоничлогчдоос нутаг бэлчээрээ хамгаалах хөдөлгөөн түгээмэл гарч байсны дотроос Ордосын ардын дугуйлангийн хөдөлгөөн далайц, зохион байгуулалтаар гаргуун байсныг тэмдэглэх нь зүйтэй.

Бавуужав бол зарим түүхчдийн үздэгчлэн дээрэмчин, Японы тагнуул байгаагүй. Харин монголчуудын төрийн тусгаар тогтолын төлөө харьшгүй тэмцэгч, халуун эх оронч хүн байлаа, зорилгоо биелүүлэхийн тул ашиглаж болох бүх хүчнийг түшиглэхийг оролдож байснаар нь түүний бүх үйл ажиллагааг харлуулж болохгүй.

2. Гурван этгээдийн хэлэлцээр нь ДИУ зөвхөн Ар Монгол, Хөлөнбуйрын баргаас бусад монгол угсаатныг бүрэн ноёрхох эрхтэй болгосон билээ. ДИУ түүнээс өмнө Өвөр Монголын засаг захиргааны зохион байгуулалтыг өөрчилж, бэлчээр нутгийг нь хятад нүүдлийн иргэдээр эзэмшүүлж тариалангийн талбай болгож, энд тэндгүй цэргийн эрхтний дэглэм тогтоосон нь монголчуудын дургүйцлийг төрүүлж, тэдний эсэргүүцэлтэй тулгарч байлаа.

Ар Монголын хувьд гэвэл ДИУ гурван этгээдийн хэлэлцээрийн дагуу Их Хүрээнд өөрийн сайдыг, Улиастай, Ховд, Хиагт зэрэгт түүний туслах түшмэдийн газрыг тогтоосон тооны хамгаалах цэргийн хамт суулгахын тул тэдгээрийн эрх үүргийг тодорхойлсон дүрэм хэмжээг батлан гаргаж хэрэгжүүлэх ажилд шуурхайлан оров. Харин ДИУ-ын ерөнхийлөгчөөс Автономит Гадаад Монголын Жибзундамба хутагтад хэлэлцээр ёсоор Богд хаан цол өргөмжлөхийг Монголын эрх баригчид эсэргүүцэж жил гаруй саатуулсан байна. Түүнчлэн «Олноо өргөгдсөний» гэдэг оны цолоо орхихгүй хэрэглэсээр байсныг ДИУ чандлан эсэргүүцэж хориглов. Монголд ажиллаж байсан хятад худалдаачид өгүүлэн буй үед ихэд идэвхжиж монголчуудаас урьдын өр, үндэсний эрх чөлөөний хувьсгалт тэмцлийн үед учирсан хохирол зэргийг нөхөн төлүүлэхийг шаардах болсныг орон нутгийн монгол эрх баригчид хүлээн авч харьяат ард иргэдээрээ, уг өр төлөөсийг гаргуулахыг оролдох боллоо.

Урьд нь Олноо өргөгдсөн Монгол улстай нэгдээд байсан Хөлөнбуйрын баргыг гурван этгээдийн хэлэлцээгээр салгаж улмаар 1915 оны 11-р сард ДИУ, Оросын хэлэлцээрээр «Хөлөнбуйрын тусгай орон» гэгчийг байгуулан ДИУ-д захируулсан нь Баргын олон нийтийн хүсэл, эрмэлзэлд огт нийцээгүй шударга бус тулгалт болсон тул үндэсний эрх чөлөөний төлөө тэмцлийн гал дахин ноцох голомт бий болгосон ажээ.

3. Монгол орон улс төрийн гүнзгий хямралд орсон XVII зууны үед Хаант Орос улсын эеэр татах, эзлэн дагуулах бодлогод өртөж Орос улсын захиргаанд орсон Буриад Монголд XX зууны эхээр хүчтэй өрнөсөн ҮЭЧХ-ий эрч далайц, өгүүлэн буй үед саарсан боловч хараа-

*Одоогийн ӨМӨЗО-ы Улаанхад хот.

хан тасраагүй байлаа. Харин 1917 оны 2-р сард Орос оронд хөрөнгөтний ардчилсан хувьсгал ялж хаант засгаа түлхэн унагаасны дараа Буриадад ҮЭЧХ дахин сэргэж буриадууд хаант засгийг устгасныг сайшаан, газрын асуудлыг үндсээр нь хянан үзэх, буриадын үндэсний автономийг тогтоох, үндэсний соёлын байгуулалтын асуудлыг шийдвэрлэх шаардлага дэвшүүлэн тавих болов. Төдхөн тэмцлийн мөрийн хөтөлбөр, тодорхой зорилго бүхий зохион байгуулалттай боллоо. ҮЭЧХ-ий өрнөлтийн манлайд Буриадын эрдэмтэд, улс төр, шашны зүтгэлтнүүд болон баян давхаргын төлөөлөгчид байлаа. Буриад-Монголын нийгмийн зүтгэлтнүүдийн хэд хэдэн удаагийн хэсэгчилсэн зөвлөгөөн болсны дараа 1917 оны 4-р сард Чита хотод Өвөрбайгаль муж, Эрхүү губернийн буриадуудын нийт үндэсний анхдугаар их хурал Б. Б. Барадина, М. Н. Богданов, Элбэгдорж Ринчино, Цэвээн Жамца рана нарын удирдлагаар хуралдаж Оросын хөрөнгөтний түр засгийн газрын бодлогыг дэмжихийн хамт Эрхүү Өвөрбайгалийн буриадуудыг сум, хошуу аймгийн зохион байгуулалтад оруулж нэгтгэх «Буриадын үндэсний автономийн төсөл» гэгчийг баталжээ. Түүнчлэн буриадын бүх сургуульд эх хэлээр хичээл явуулах, монгол-буриад хэл, буриад монголын түүх, Монгол утга зохиолын түүх, буриад судлал зэрэг хичээл оруулах зорилт дэвшүүлснээс гадна нийт үндэстний дараачийн их хурлуудыг зохион байгуулах үндэсний хороо байгуулсан байна.

Буриадын үндэсний хороо, түүний Эрхүүгийн хэлтэс болон буриад аймаг хошуудад байгуулагдсан үндсэний байгууллагууд нь нийт үндэсний их хурлуудаас тогтоосон хөтөлбөрийн дагуу ажиллаж байлаа.

4. 1917 оны 10-р сард Орос оронд гарсан хувьсгалаар байгуулагдсан Зөвлөлт засгийн газар энх тайвны тухай хууль нийтлүүлж, түүндээ: «...их оросынхны булаасан газар нутгийг хэвээр байлгах буюу улам тэлэхэд ихэнхдээ чиглэж байсан тэдгээр бүх нууц гэрээг үг дуугүй, нэн даруй хүчингүй болгож байгааг тус Засгийн газар зарлан мэдэгдэж байна»¹¹ гэснээс гадна Монгол, Хятад зэрэг оронд тусгайлан хандаж уриалга гаргасан билээ.

Тэр үед ДИУ-ын засгийн эрхэнд Японы талыг барьсан цэргийн эрхтнүүд зонхилж байлаа. Тэд Зөвлөлт Орос Улсаас сэрэмжлэх нэрийдлээр Япон улстай цэргийн талаар хамтран ажиллахаар 1918 оны 5—9-р сард Бээжинд гурван нууц хэлэлцээр байгуулжээ. Тухайлбал, Дундад, Японы хуурай замын цэргийн тухай хэлэлцээрт хойд Манжуур Гадаад Монголын тухай тусгайлан заасан зүйлд Сибирьт байсан олзлогдсон чехословак цэргийн бослогыг дэмжиж, Герман-Австрид туслахын тулд Манжуурын төмөр замаар Өвөр байгаль руу япон дарга нарын удирдсан хятад цэрэг оруулах, Гадаад Монголын Их Хүрээнээс Байгаль нуурын зүг Хятадын цэрэг ангийн нэг хэсгийг оруулах, Монголын баруун хил хязгаарыг ДИУ батлан хамгаалах, цэргийн хэрэгцээт зүйлийг тээвэрлэх, нийлүүлэх, газар орны байдлын тухай мэдээлэл солилцох зэрэг олон арга хэмжээг заасан ажээ¹². Дундад, Японы цэргийн хамтын ажиллагааны эдгээр хэлэлцээрт ДИУ Гадаад Монголын автономийг устгаж эзлэх, Япон Манжуурыг түрэмгийлэн эзлэх санаа туссан юм. ДИУ уг хэлэлцээрээ даруй хэрэгжүүлэх замд орж Гадаад Монголыг «улаан Оросын аюулаас» хамгаалах нэрийдлээр 1918 оны 9-р сард цэргийнхээ түрүүч хоёр морин хороог ирүүлж Хүрээ, Хиагт, Улиастай, Ховд зэрэг чухал газар нутагт байрлуулав.

Зөвлөлт Орос Улсын Засгийн газар тус хоёр орны хооронд тэгш эрхтэй найрамдалт харилцаа тогтоох тухай Богдын Засгийн газарт 1918 оны эхээр албан ёсоор мэдэгджээ. Дараа нь 1919 оны зун монгол үндэсний олон аймаг ба Автономит Монголын Засгийн газарт илгээсэн тунхаг бичигтээ: «Оросын ард түмэн Монголын тухай Япон, Дун-

дад хоёр улстай урьд хааны үед тогтоосон аливаа гэрээ бичгийг цөм устгасны учир үүнээс хойш Монгол өөртөө эрхт тусгаар нэгэн орон мөн... Засгийн бүрэн эрх ба шүүх таслах хэргийг цөм Монголын хязгаар дотор гагцхүү Монгол өөрөө эрхлэн мэдвэл зохино. Монголын дотоод хэрэгт ямар ч гадаадын хүн оролцох эрхгүй» гэхийн гадна мөнөөхөн 1912 оны гэрээ бичгийг зогсоож, Монгол улс тусгаар тогтносон орны ёсоор Бээжин Петроград хоёроос асуулгүй аливаа олон улстай шууд харилцан нэвтрэлцэх эрхтэй болсон явдлыг манай Зөвлөлт Засгийн газраас монгол үндэстний улсад чухам мэдэгдэн тунхаглахын хамт манай Орос улстай даруй харилцан нэвтрэлцэж элчин явуулан эрх чөлөөт Монгол улсын төлөөний хүмүүсийг манай улаан цэргийн Өмнөөс тосон илгээх ажаамуу»¹³ гэж мэдэгдсэн байна.

АНУ-ын ерөнхийлөгч Вильсон 1918 оны 1-р сарын 8-нд Конгрессдоо явуулсан илгээлтдээ¹⁴ зүйл бүхий энх тайвны хөтөлбөр гэгчээ дэвшүүлж, эцсийн зүйлд нь их бага улсуудад улс төрийн тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдал харилцан адил баталгаатай болгохын тул үндэстнүүдийн холбоо байгуулах санал тавьжээ.

Энэ бүхэн нь олон оронд, ялангуяа монгол мэтийн дарлагдсан буурай оронд өрнөж буй ҮЭЧХ-нд өөр өөр чиглэл гарахад нөлөөлөв. Аливаа ҮЭЧХ зорилгодоо хүрэхийн тул түшиг болохуйц хүчин бүхнийг ашиглах ёстой билээ.

5. Дэлхийн анхдугаар дайн дуусаж, ертөнц хуучин, шинэ хоёр систем болон хуваагдаж аль аль нь аливаа үндэстэн, ард түмний өөрөө засан тохинох эрхийг хүндэтгэн дэмжиж туслахаа илэрхийлэх болсон үед дарлагдсан ард түмнүүд дотор үндэс угсаатнаараа нэгдэж улсаа байгуулан хөгжих эрмэлзэл бадарч байсны нэг жишээ бол монгол угсаатнууд нэгдэж Их Монгол улсаа сэргээж байгуулах хөдөлгөөн гарсан явдал мөн. Гэтэл монголчуудын хүчин чармайлт, хүсэл эрмэлзлийг огт харгалзахгүй, дан гаднын, тухайлбал, Семенов тэргүүтэй Оросын цагаантан Японы түрэмгийллийн явуулга гэдгээр өрөөсгөл тайлбарлаад хэдэн оронд хуваагдмал амьдарч байсан монгол угсаатанд үндсээ мэдэрч өөрийн тусгаар тогтносон улсыг байгуулах ухамсар байгаагүй юм шигээр бичиж түүх гуйвуулсаар байна.

ЗОУ-ын Улаан цэргийн хүчинд цохигдон Өвөрбайгал руу шахагдан ирсэн цагаан цэргийн генерал Г. М. Семенов (1890—1946) буриад, барга, Дотоод Монголын үндэстний эрх чөлөөний төлөө тэмцэгчидтэй холбоо тогтоож, тэднийг өөртөө татах, Манжуур, Монголын талаар идэвхтэй бодлого явуулж буй Япон улстай харилцаж дэмжлэг авахыг оролдож эхэлсэн нь Их Монгол улс байгуулахын төлөө хөдөлгөөн өрнөхөд түлхэц болов. Ар Монгол, ДИУ-ын хатуу хяналтанд автономит эрхтэй байсан учраас дээрх хөдөлгөөнийг үүсгэн зохион байгуулагчид Өвөр Монголоос эх орныхоо хувь заяаны төлөө санаа тавьдаг, олонд нөлөөтэй нэг гэгээнийг гаргаж ирэх хэрэгтэй гэж үзсэн учраас Өвөр Монголын Жирэмийн чуулганы Жалайд хошуунд төрсөн Хөх хотын Нэйс гэгээн Мэндбаяр гэгч залууг Их Монгол улс байгуулах хөдөлгөөнд татан оруулж Семеновтой нягт хамтран ажиллуулах болсон юм. Мэндбаяр анх 1918 оны 12-р сард өөрийн харчин цэргийн хамт Семеновтой нийлсэн ажээ. Зохих бэлтгэл хийгээд 1919 оны 2-р сарын 25-нд Буриадын Чита хотноо монгол овогтны их хурал нээгдэхэд Буриад, Барга, Өвөр Монголоос бүгд 16 хүн оролцсон байна. Их хуралд Семенов туслах, орчуулагч нартайгаа, мөн Японы ажиглагч оролцжээ. Мэндбаяр их хурал нээж товч үг хэлэхдээ: «Чингис хааны үед бүх монгол аймаг бүхэл нэг байснаа монголчууд сулран доройтсоны улмаас тэдний зарим нь Хятадын захиргаанд, нө-

гөө зарим нь Орос улсын захиргаанд орсон билээ. Одоо үед бүх монгол аймгийг нэгэн улс болгон шинээр нэгтгэх аятай боломж бий болж байна»¹⁴ гэжээ.

Тус их хурал Буриад, Барга, Ар, Өвөр Монголыг тус бүрд нь өөртөө засах эрхтэйгээр холбооны улс болгон нэгтгэж, биеэ даасан Монгол улсыг зохион байгуулах тухай тогтоол гаргасан билээ. Их хурал Нэйс гэгээн Мэндбаяр тэргүүтэй түр засгийн газрыг цэрэг, дотоод явдал, сан, гадаад явдлын зэрэг дөрвөн яамтай байлгахар шийдвэрлэж, Их Монгол улсыг бүрдүүлэх үндсэн дөрвөн хэсгээс тус бүр хоёр хүнийг жинхэнэ орлогч сайдаар томилсон боловч Ар Монгол ДИУ-ын цэргийн шууд хяналтад ороод байсан тул төлөөлөгч нь оролцоогүй юм. Тэгээд 1919 оныг «Монгол улсын тэргүүн он» гэж цоллож, улсаа батлан хамгаалахын тул Өвөр Монголоос 20000, баргаас 1000, Буриадаас 3000 хүн дайчилж цэрэг байгуулаад байрлах газрыг нь заасан шийдвэр гаргажээ. Түр засгийн газар байгуулагдсан өдрөөсөө эхлэн их гүрнүүдэд өөрийгөө зарлаж, тэднээр зөвшөөрүүлэх, Ар Монголын засгийн газрыг өөртөө татах бодлого явуулж, Парисын Олон улсын найрамдлын бага хуралд төлөөлөгчдөө оролцуулахыг оролдсон боловч холбоотон гүрнүүдийн элчин Японоор дамжиж очсон Монголын төлөөлөгчдөд Франц орох зөвшөөрөл олгохоос татгалзсан тул энэ хэрэг бүтсэнгүй. Япон ч Их Монгол улс байгуулах хөдөлгөөнийг зориг жуулан дэмжихээсээ болгоомжилж Семенов тэргүүтэй Оросын цагаантны байдал улам бүр доройтож байсан нь тэднийг түшиглэж гарсан Монголын ҮЭЧХ-ий нэгэн хурц илрэл аажмаар буурахад хүргэв.

Тэр үед Хятадад Манжийн төрийг сэргээхийн төлөө тэмцэж байсан Цзүншэдан намынхан Их Монгол улс байгуулах хөдөлгөөнийхнийг ДИУ-ын эсрэг ашиглахыг оролдож байлаа. Гэтэл уг хөдөлгөөн тэдэнд ч, Оросын цагаантанд ч ашиглагдаж ДИУ ба ЗОУ-ын эсрэг ноцтой хандалгүй замхарсан боловч зарим зүтгэлтэн нь Монголын өөр нутагт өөр нөхцөлд тэмцлээ үргэлжлүүлсэн билээ.

6. Тулгар тогтсон ЗОУ дотоодынхоо дайны улмаас хүнд байдалд орсноор ДИУ, Японтой байгуулсан цэргийн талаар хамтран ажиллах хэлэлцээрээ хэрэгжүүлэх аятай боломж бүрдлээ хэмээн үзэж Гадаад Монгол, Хөлөнбуйрын Баргад явуулж байгаа бодлогоо нэн идэвхжүүлж, эдгээр нутаг орны эрх баригчдын дотроос үндэсний ухамсар дорой, эрх тушаал, цалин фүнлүд дуртай, тогтворгүй этгээдүүдийг өөртөө татаж Гадаад Монголын автономи, Хөлөнбуйрын тусгай орны эрх мэдлийг устгах явуулгыг арга, хүч хослон хийв. Тийнхүү автономит засгийн, Хятадын талыг баримталсан зарим эрх баригч, Монголын тусгаар тогтнолын төлөө тууштай тэмцэгч манлайбаатар Дамдинсүрэн, хатанбаатар Магсаржав нарын зэрэг цэргийн жанжин, гарамгай эх орончдыг хил хязгаар сэргийлүүлэх нэрийдлээр нийслэлээс зайлууллаа. ДИУ-аас Нийслэл хүрээнд суугаа сайд Чэнь И Монголын автономит засгийн ерөнхий сайд Бадамдорж, дэд сайд Пунцагцэрэн, Цэргийн яамны тэргүүн сайд Жамъяндорж нарын зэрэг төр шашны эрх баригчидтай сэм хуйвалдаж автономийг устгуулах явуулга хийхдээ Зөвлөлт Оросын зүгээс учрах «улааны аюул» гэгчийг зохиомлоор дэвэргэж байлаа. Монголын эрх баригчдын Хятадын талыг баримтлагчид «улааны аюулаас» сэрэмжлэхийн тул автономит эрхээ устгаж ДИУ-ын шууд захиргаанд орохын чухлыг Улсын дээд, доод хурлын гишүүдэд ятгах, мэхлэх, сүрдүүлэх олиггүй арга бүхнийг хэрэглэж байсан нь эх оронч монгол хүн бүхнийг түгшүүлэх болов. 1919 оны 11-р сарын 15-нд Улсын доод хурал автономийн тухай асуудал хэлэлцэхэд Д.Сүхбаатар оролцож үг хэлэхдээ: «Эдүгээ манай монгол засгийн эрх баригчид,

өөрсдийн нэр ашиг, эрхийг эрхэмлэн улс төрөө Хятадад найр тавин худалдаж бүхий байдлыг манай цэрэг, ард нэлээд урьдаас тосож мэдсэн билээ... Одоо харин урьдхыг бодвол цэрэг зэвсгээр нэлээд хүчирхэг болсон хэмээвэл болох цагт Хятадтай эсэргүүцэн байлдахаас огт айхгүй билээ...¹⁵ гэж мэдэгдэж байжээ. Хаан Жибзундамба хутагт автономно устгуулахгүйн төлөө тууштай зогсож байлаа. Иймээс тэр үест цэрэг захиран зүүн хязгаарыг сэргийлэн сууж байсан манлай баатар ван Дамдинсүрэн: «Хятадад дагаж болохгүй. Хятад ба улаан Орос хоёуланг оруулахгүй сахихыг би батлан хүлээнэ» хэмээн Богд хаанд яаралтай айлтгасныг замаас дарагдуулаад нэвтрүүлэн айлтгаагүй ажээ¹⁶.

Хойд Хятадын цэргийн эрхтнүүд Сюй Шүчжэн гэгчийг Баруун хойд хязгаарын хэргийг бодуулан шийтгэх сайдаар томилон Ар Монголыг цэрэглэн эзлүүлж, 1919 оны 11-р сарын 22-нд түүний автономит байгууллыг устгав. Мөн Хятадын цэргийн эрхтнүүд Хөлөнбуйрын баргын тусгай орныг 1920 оны 1-р сарын 28-нд устгаж ДИУ-ын шууд харьяанд оруулснаар монголчуудын үндэсний эрх чөлөөний хувьсгалт тэмцлээр байлдан олсон ололт бүрмөсөн үгүй болж, Монгол орныг харийн түрэмгийллийн аюул дахин нөмөрсөн юм. Монголын эх орончид ч Хятадын ноёрхлоос ангижирч, төрийн тусгаар тогтнолоо сэргээх эхний алхам-алдагдсан автономит эрхээ сэргээх элдэв арга зам сүвэгчлэх болов. Монголчууд дан өөрийн хүчээр, эсвэл АНУ, Япон зэрэг хүчирхэг гүрнүүдээс тусламж эрэхээс гадна Орос улсын доторх эсрэг тэсрэг хүчин тус бүрийг түшиглэн автономит эрхээ сэргээх оролдлого идэвхтэй хийж эхэлжээ. Энэ бүх нууц байдалд зөвхөн итгэлтэй хүмүүсийн дунд явагдаж байв. Тухайлбал, Олноо өргөгдсөн Монгол улсын төлөө зүтгэж дайчин нөхөрлөлөөр гагнагдсан манлайбаатар Дамдинсүрэн, хатанбаатан Магсаржав хоёр автономит эрхээ эгүүлэн авах талаар байнга зөвлөлдөж, эх оронч зарим лам, ноёд хүртэл тэднийг тойрон хүрээлэх болов. Дамдинсүрэн Магсаржав нар ойрын аймаг, хошуудаас цэрэг сэмхэн дайчилж тэдэнд Богдын ордонд хадгалагдаж буй буу зэвсгээс олгох, цэргийн агтанд Богдын есөн цагаан гэдэг сүргийн морьдыг хэрэглүүлэн хятад цэргийг хөөн гаргахаар зөвлөлдөж байв¹⁷.

Нийслэл Хүрээнд 1918—1919 оны заагаар үүссэн эх орончдын хоёр нууц бүлэг Хятадын цэргийн эрхтнүүдийн дарангуйллаас эх орноо чөлөөлж, автономит эрхээ сэргээх талаар эрчимтэй ажиллаж, улмаар Оросын хувьсгалчид хийгээд Коминтерний төлөөлөгчтэй ажил хэргийн нууц холбоо тогтоож 1920 оны 6-р сарын 25-нд Монгол Ардын Нам (МАН) гэдэг хувьсгалт байгууллага болон нэгдэж «Намын хүмүүсийн дагаж явах тангаргийн бичиг» гэдэг мөрийн хөтөлбөрийн чанартай баримт бичиг батлан, зорилгоо тодорхойлохдоо: «...шашин үндсэнд харшлах дайсныг цэвэрлэж, алдагдсан эрхийг эргүүлэн аваад, төр шашныг үнэн сэтгэлээр бататган мандуулж, үндэс язгуурыг алдагдахгүй ба дотоод засгийг үнэн сэтгэлээр сайжруулан засамжилж, ядуу дорд ард түмний тусыг туйлаар бодох ба өөрийн дотоод эрхийг өнө үүрд сахиж, дарлах дарлагдахын зовлонгүй аж төрөхийг чухал болгоно»¹⁸ гэж заасан байна. МАН Зөвлөлт Орос Улсаас автономит эрхээ сэргээх хэрэгт тусламж эрэх төлөөлөгчдийг томилон Богд хааны тамгатай бичгийг авахуулан нууцаар явуулсан билээ. Энэ хэрэг нууц явагдсан боловч, Орос улсаас тусламж эрэхээр төлөөлөгчид явсан гэнэ, удахгүй орос цэрэг ирж Монголыг Хятадын ноёрхлоос чөлөөлөх гэнэ гэдэг яриа олны чих дэлсэх болсон үеэр Оросын цагаан цэргийн ноён Семеновынхон улаан цэрэгт цохигдон сарниж Сэцэн хан аймгийн хойд хязгаар нутгаар тулж ирэв. Цагаан цэргийн ангийг урьд Монголд байсан барон Унгерн гэгч захирч явжээ. Тэр Монгол орны байдлыг мэдээд

1920 оны намар Богд Жибзундамба хутагтад ирүүлсэн захидалдаа: Оросын хаан угсааны барон Унгерн би Орос, Монголын язгуурын найртай сайны ёсоор Богд хаанд тус хийж, Монголыг харгис Хятадын дарлагдлаас ангижруулан хамгаалж тохинуулахын тул цэрэг авч Хүрээнд орох зорилго бүхий тул олдваас Богд хаан танаас зөвшөөрөл олгож хариу ирүүлэх ажаамуу»¹⁹ гэснийг Богд ихэд сайшааж, түргэн иртүгэй гэсэн хариу яаралтай өгсөн ажээ.

Монголчуудын дотор энэ мэтээр эсэргүүцэл өрнөж байгааг хятад цэргийн эрх баригчид мэдээд шууд баривчилга явуулж эхэлсэн юм. Тухайлбал, жанжин манлайбаатар Дамдинсүрэн, хатанбаатар Магсаржав нарыг дэмжигчдийнх нь хамт 1920 оны 9-р сарын 10, 11-нд, Богд Жибзундамба хутагт болон түүний шадар бараа бологчдыг 10-р сарын 26-нд тус тус баривчлж хорьсон нь монголчуудын хилэнг бадраалаа. Хятадын зандалчдыг аль болох түргэн хугацаанд үлдэн зайлуулж, эх орноо чөлөөлөхийн төлөө улс үндсээ боддог Монгол хүн бүр хот хөдөөгүй санаа зовж тэмцэх болов. Тухайлбал, Сэцэн хан аймгийн Санбэйсийн хошууны* мээрин өндөр хэмээх хочтой Нарангийн Дугаржав гэгч урьд Хужирбуланд хамт цэргийн сургууль хийж байсан Сүхбаатар, Данзан нарын хэдэн хүн Орос улсаас тусламж эрж хойд зүг явсан гэж дуулсан байжээ. Гэтэл төдхөн тэдний нутгийн захад орос ноён удирдсан олон цэрэг орж ирээд Их хүрээг Хятадаас чөлөөлнө гэж явах нь тэдний авчирч байгаа хүчин ч байж магад, эд үнэхээр Их Хүрээг чөлөөлбөл цаг үеийн гавьяат үйлс мөн гэж үзээд хүчин хавсралцаж нутгаас цэрэг элсүүлэх, цэргийн хэрэглэл бэлтгэх ажилд шуурхайлан оролцсон байна. Түүнчлэн Түшээт хан аймгийн Дархан чин вангийн хошууны* тэргүүн зэрэг тайж Лувсанцэвээн (Цэвээн ч гэдэг) Сэцэнхан аймгаас цэрэг элсүүлж яваад, олон цэрэг захирсан, барон Унгернтэй уулзаж Хятадын түрэмгийлэгчдийг цохиж, Монголын автономийг сэргээх үйлсэд хамтран тэмцэхээр тохиролцож цэрэг зэвсгээ базааж Нийслэл Хүрээний зүг давшсан ажээ. Монголын үндэсний эрх чөлөөний төлөө тэмцэгчид энэ хөдөлгөөнд олон монгол угсаатныг татан оролцуулж зөвхөн Ар Монголын автономийг сэргээгээд зогсохгүй нийт монгол угсаатны тусгаар тогтнолыг сэргээх зорилт тавьж байв. Иймээс Их Хүрээ болон бусад хот, нутаг орныг Хятадын зандалчдаас чөлөөлөх тэмцэлд буриад, барга, Дотоод Монголын цэрэг дарга нар халх, орос цэрэгтэй мөр зэрэгцэн таван сар тулалдсаны эцэст Нийслэл Хүрээг чөлөөлж, 1921 оны 2-р сарын 22-нд Гадаад Монголын автономийг сэргээж Жибзундамба хутагтыг хаан ширээнд өргөмжлөх, дотоод зэрэг таван яам байгуулж, тэдгээрийн тэргүүн дэд сайд, жанжин нарыг томилох, Хятадын түрэмгийлэгчдийг бут цохиж хөөхөд идэвхтэй хүчин зүтгэгчдийг хөхүүлэн шагнах зэрэг ёслолын ажиллагаа болсон нь Монголын ҮЭЧХ-ий хоёр дахь үеийн том амжилт байв. Засгийн газрыг байгуулахад ерөнхийлөн шийтгэх сайд бөгөөд Дотоод яамны тэргүүн сайдад Жалханз хутагт Дамдинбазар, Монгол цэрэг байгуулан зохион байгуулж, шургуу тулалдахын зэрэгцээгээр Оросын цагаантан барон Унгернийг чадамгай ашигласан Лувсанцэвээнийг Сангийн яамны тэргүүн сайд, чин вангийн хэргэм, бат ерөөлт жанжин цол, хатанбаатар Магсаржавыг Монголын бүх цэргийн жанжнаар тус тус томилж, орос жанжин барон Унгернд хан зэрэг, дархан чин вангийн хэргэм, улсыг мандуулагч их баатар жанжин цол шагнасан байна.

*Бэйс Сансрайдоржийн хошуу (одоогийн Дорнод аймгийн нутаг),

*Дархан чин ван Пунтагэрэнгийн хошуу (одоогийн Төв аймгийн Баяндэлгэр, Баянзүрх, Баянцогт, Эрдэнэ, Баян зэрэг сумын нутаг, Улаанбаатарын орчим нутаг юм).

Ийнхүү автономит засгийг сэргээхдээ яамдын тэргүүн, дэд сайд, түшмэдийг аймаг шавиас адил тэнцүүлэн томилжээ. Сэргээн байгуулсан засгийн газар хятад цэргийн үлдэгдлийг цохин зайлуулахаар тал бүр тийш цэрэг дайчлан мордуулж, нутаг орноо чөлөөлөх тэмцлээ үргэлжлүүлэв. Мөн хөрш Орос, ДИУ-д албан бичиг явуулж Монголын автономит төр сэргэснийг мэдэгдэж найрамдалт харилцаа тогтоон хөгжүүлэх саналаа илтгэхийн хамт орон тус бүрд өөрийн бодлогыг илэрхийлсэн ажээ. Тухайлбал, Автономит Засгийн газраас 1921 оны 2 дугаар сарын 25-нд Зөвлөлт Орос улсын Гадаад хэргийн комиссарт явуулсан бичигтээ монголчууд автономит эрхээ сэргээж Богдыг хаан ширээнд дахин залснаа мэдэгдээд, «Эрт урьдаас Их Орос улс, манай Монгол улсад ихээхэн тус хамгаалал үзүүлсээр ирсэн бөгөөд Монгол улсын автономит эрх олгоход тусламж үзүүлсэн учир Монголын чөлөөт ардаар Их Орос улсын ардтай үргэлж зузаан найрамдалтай байх учрыг манай засгийн газраас батална» гээд Хятадын цэргийн эрхтний «...хууль дүрэм ба үнэнийг эвдсэн сайдуудыг тэдний цэргийн хамт Монголын Нийслэл Хүрээнээс, Оростой хүчин хавсарч хөөн гаргасан амуй. Энэхүү орос нар эрхэм комиссар та нартай санаа нийлэлцэхгүй эсэргүүцэж бүхий явдлыг бид мэднэ... Оросын Засгийн газраа санаа нийлэлцсэнгүй эсэргүүцсэн орос цэргүүд баруун зүгт одохыг завдан буй тул Орос Монгол хоёрын найрамдалд саад хийх зүйл үгүй буй заа хэмээн манай засгийн газар санана» хэмээгээд хоёр улсын хооронд худалдааны гэрээ байгуулж, элчин төлөөлөгч солилцон сайн хөршийн харилцаа тогтоохыг хүссэн байна. Мөн оны 3-р сарын 2-ны өдөр ДИУ-ын Ерөнхийлөгчид явуулсан бичигтээ, Гадаад Монголын авто номийг ДИУ биш харин Сүй Шүчжэн тэргүүтэй цэргийн эрхтнүүд устгаж «Их Дундад улсын эрхийг эвдэх хэмээсэн ба мөн муу дээрэм зэргийг үйлдэж бүхий сайд Гао сылин-гийн цэрэг лүгээ байлдахаар монголчууд барон Унгерний цэрэгтэй нийлэхээс өөр замгүй болсон билээ. Одоо Монголын хязгаараас цэргийн сайд Гао сылин өөрийн цэргийн хамт зайлсан тул гадаадын орос цэргийг агуулж байх нь зохихгүй учрыг гаргаж цэргийн жанжин барон Унгернд хэлбээс, тэр барон Унгерн бээр зөвшөөрч би өөрийн цэргийг авч хойд зүг явна хэмээн батлан хариу өгөв» гэж барон Унгернийг түр ашигласнаа тайлбарлаад Монголын автономит хэрхэн устсаныг: «Сүй Шүчжэн, түүний захиргааны цэргийн сайд Гао салингийн хамт ирж Дундад улсын хуулийн төлөөлөгч Чэнь И-гийн биеийг хар гэрт хорьж, цэргийн сүрээр Монголын Засгийн газар ба Богд хутагт хааныг айлгаж эрхийг булаан авах байтугай эрхээ дуртайяа өгөв хэмээх бичиг хийлгэж авсан буй. Тэрхүү батлах бичигт Богд хаан өөрөө тамгаа дарсан бус учрыг хамтаар гаргасугай. Сүй Шүчжэн ба түүний цэргийн сайд нарын хийсэн хэргийг Бээжингийн Засгийн газар сайшаасангүй. Сүй Шүчжэнгийн биеийг дуудан аваачаад, түүний оргосны сүүлд барьсан хүнд их шагнал олгоно хэмээн зарлаж Чэнь И-д хуучин эрхийг олгосныг манай Монголын Засгийн газар мэднэ»²¹ гэх зэргээр цэргийн эрхтний ажиллагааг буруушааж, аанай л ДИУ-ын эзэн эрхэнд автономит байгуулалтайгаа байх санааг илэрхийлсэн байдаг.

Гэтэл Дотоод яамнаас 1921 оны 4-р сарын 16-нд Өвөр Монголын зургаан чуулганд явуулсан бичигтээ: «Мөнөөхөн Монгол улсад хоёр дайсан гарч ирэв. Нэг нь, хэдүйнээс бидний монголчуудад дайсан болсон Хятад улс ... нөгөө нь хойд зүгийн урвасан орос цэргүүд болох тул бид нэн хүчтэй арга хэрэглэж тэрхүү (Монгол— Л.Ж.) улсын газ-

*Сылин гэдэг нь захирагч гэсэн хятад үг Гао гэдэг нь Цзайтянь гэдэг нэрийн овог,

рыг эзэлж шашин үндсийг хорлон хөнөөх хэмээн санасан шунахай ялт бус (өөр—Л.Ж.) төрөлтнийг оруулахгүй. Манай Засгийн газраас эрхэм ноён танаа гуйх нь өөрийн шашин язгуур ба урьдын сурвалжит алдраа бодож нэгэн овогт бидлүгээ нийлж их холбоот улс байгуулбаас бидний эрт урьдаас бурхныг шүтэж чин сүсэг бишрэлтэй ирсэн монгол язгууртныг зовлонгийн далайгаас гэтэлгэж жаргуулах хэрэгт тус болно хэмээн эрмэлзэнэ»²² гэж шашны тугийн дор монгол угсаатныг холбоот улс болон нэгдэхийг уриалсан байдаг.

Ар Монголын автономийг ийнхүү сэргээсэн нь төрийн тусгаар тогтнолоо олохын төлөө хийсэн нэг том алхам, монголчуудын ҮЭЧХ-ий хоёр дахь үеийн төгсгөлийн чухал үр дүн мөн. Үүнийг манай түүх судлалд барон Унгерний эзлэн түрэмгийлсэн үе, түүний байгуулсан тоглоомын автономит засгийн үе гэж нэрлэж, Монгол оронд болсон улс төрийн ноцтой үйл явдал бүр гаднын явуулга мэтээр монголчуудыг басамжилдаг харийн их гүрний дээрэнгүй үзлээр өрөөсгөл дүрсэлж ирснийг хянан үзэх цаг болжээ. Үнэн байдал тийм бус, монголчууд автономит эрхээ сэргээхийн төлөө тэмцэлдээ барон Унгерний хүчийг ашиглаж байсан юм. МАН, ардын засгийг үндэслэн байгуулагчийн нэг Догсомын Бодоо хүртэл барон Унгерний дэргэд түр ажиллаж, тэднийг «Гэминтэй дахин байлдуулж, чадвал тэдний гараар гэминг зайлуулах бодлогыг тавьж, барон Унгерний цэргүүдэд түлхээс өгч байсан»²³ билээ.

Монголын хувьсгалт байгууллагын төлөөлөгчдөөс 1921 оны 2-р сард ардын журамт цэрэг элсүүлэх тухай гаргасан уриалгадаа: «...Энэ завсар манай Монголын хэдэн шударга үнэнч түшмэд зүүн зүгээс монгол цэрэг элсэж, цэргийн баатар зориг хүчнээр Хүрээнд бүхий хятад гэмин цэргийг дайран орж Богд хааныг булаан залж, дараагаар дайсан цэргийг хөөн гаргаж Нийслэл Хүрээг нэгэнт эзлэн авсан»²⁴ гэж бичсэн нь барон Унгерн дан өөрийн хүчээр Нийслэл Хүрээг чөлөөлж автономит засгийг байгуулаагүй, харин монголчууд үндэснийхээ эрх чөлөөний төлөө өөрийн цэрэг, зэвсгийг бэлтгэн тэмцэхдээ барон Унгерний хүчийг ашигласныг харуулж байна. Унгерн ч бас ЗОУ-ын эсрэг тэмцэлдээ монгол нутаг, хүн, хүчийг ашиглаж, багагүй хохирол учруулсныг үгүйсгэхгүй.

Энэ үеийн тэмцэл нь Монголын янз бүрийн хэсэгт уван цуван гарсан боловч цөм л монгол угсаатны үеэс үед уламжилж ирсэн нэгдмэл Их Монгол улсаа сэргээх мөрөөдлийг шарын шашны тугийн дор Ар Монголоор төв болгон хэрэгжүүлэх зорилготой байлаа. Тийнхүү тэмцэгчдийн зарим нь Хятад дахь ДИУ-ын эсрэг хүчин ба Оросын цагаантныг ашиглан далайн чанадаас тусламж авах замаар, нөгөө зарим нь ЗОУ, Коминтернээр туслуулж ҮЭЧХ-өө улам гүнзгийрүүлэн цоо шинэ үед дэвшүүлэн, үндэсний ардчилсан хувьсгал болгож төрийн тусгаар тогтнолоо байлдан олохын төлөө тэмцэж байлаа. Үүний нэг дэх буюу бидний өгүүлэн буй үеийн тэмцлийн ололт нь Ар Монголд үндэсний ардчилсан хувьсгал харьцангуй түргэн ялахад дөхөм болсноороо түүхийн чухал ач холбогдолтой юм.

1. 1911 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний удирдагч «Дорно дахины судлалын асуудал, сэтгүүл. УБ. 1988. № 2.
Монголын цагаагчин гахай жилийн хувьсгал. — «Дорно, өрнө» сэтгүүл. - 1991 № 3.
2. Л. Жамсран манлайбаатар Дамдинсүрэн түүний шинэтгэлийн бодролууд. УБ. 1991. Монголын сэргэн мандалтын эхэн. УБ. 1992
- 3 Цагаагчин гахай жилийн хувьсгалын ялалт бол Монголын орчин үеийн сэргэн мандалтын эхэн, — «Чөлөөт хөдөлмөр» сонин. 1991, № 18, 19,
- 4 Улсын түүхийн төв архив (УТТА) ФА—2. х. н. — 196, нуг, 23,
5. УТТА ФА-2, х, н, —196, нуг 19
- 6 Мөн тэнд
7. Мөн тэнд, нуг. 20.
8. Л. Жамсран Жанжин манлайбаатар Дамдинсүрэн, түүний шинэтгэлийн бодролууд. УБ. 1991 28 дахь тал.
9. Магсар хурц. Монголын шинэ гарсан түүх (гар бичмэл), 3-р бүлэг.
- 10 Национально-освободительное движение Бурятского народа. Улан -Үдэ. 1989, с. 18—19.
- 11 Ленин Зохиолууд, 26-р боть 243 дахь тал
12. Хуа Чиюнь Мань Мэн вэньти (Манж Монголын асуудал), Шанхай, 1931, 292—293 дахь тал
- 13 1921 оны ардын хувьсгалын түүхэнд холбогдох баримт бичгүүд, 1917 1921. УБ. 1957 35—36 дахь тал
- 14 П. Т Хаптаев. Бурятия в годы гражданской войны. Улан-Үдэ, 1967. с 54
- 15 Л. Бат-Очир, Д. Дашжамц. Дамдингийн Сүхбаатар (намтар). УБ., 1973 57 дахь тал,
16. Дилав хутагт Жамсранжав, Ар Монголын улс төрийн дуртгал УБ. 1991 20 дахь тал.
- 17 Ш. Нацагдорж, Манлайбаатар Дамдинсүрэнгийн товч намтар. УБ., 1946 53—54 дэх тал
18. МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд—1, УБ 1966.7 дахь
19. Л. Дэндэв. Монголын товч түүх. УБ. 1934, 191 дэх тал.
- 20 УТТА ФА-4 х н — 621 нуг. 67.
- 21 УТТА ФА-4 х, Н— 621. нуг 3.
- 22 Мөн тэнд нуг. 12
- 23 Х. Чойбалсан Д. Лосол Г. Дэвид Монгол ардын үндэсний хувьсгал анх үүсэж байгуулагдсан товч түүх 11 хэвлэл. УБ., 1979, 179 дэх тал
- 24 МАХН ардын хувьсгалын ялалтын төлөө тэмцэлд (баримт бичгүүд), УБ. 1971 79 дэх тал